

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70005329 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

Г ӨМНӨД БҮСИЙН ТӨВ ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Г.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2022.02.16 № 40
танай _____ -ны № _____ -г

Г _____ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Д/2021 Он Бичиг Хэрэг Явсан Бичиг/2022-02-16 №40'с

010300000

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	/төгрөг/ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	264,688,050.81	674,020,906.81
35	БАРАА МАТЕРИАЛ	264,688,050.81	674,020,906.81
351	Түүхий эд материал	63,997,319.81	75,926,995.81
35110	Тусгай зориулалттай материал	63,997,319.81	75,926,995.81
354	Хангамжийн материал	199,720,731.00	597,123,911.00
35410	Бичиг хэргийн материал	171,900.00	391,900.00
35420	Аж ахуйн материал	25,709,062.00	25,691,562.00
35440	Түлш шатах тослох материал	1,485,960.00	8,051,560.00
35470	Бусад хангамжийн материал	172,353,809.00	562,988,889.00
35600	Мал, амьтад	970,000.00	970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,515,834,657.74	7,202,769,555.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,515,834,657.74	7,202,769,555.00
392	Биет хөрөнгө	5,220,759,657.74	6,907,694,555.00
39201	Барилга, байгууламж	1,431,001,496.00	1,653,885,393.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(651,547,604.14)	(776,409,733.99)
39203	Авто тээврийн хэрэгсэл	5,489,845,887.33	7,767,624,487.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,306,047,679.15)	(1,985,345,290.08)
39205	Машин, тоног төхөөрөмж	607,718,156.99	659,995,386.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(425,849,686.82)	(475,262,347.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,638,850.05	164,235,973.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,930,170.92)	(102,779,660.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,512,600.00	18,512,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,582,191.60)	(16,762,253.52)
393	Биет бус хөрөнгө	295,075,000.00	295,075,000.00
39301	Программ хангамж	950,000.00	950,000.00
39302	Хасагдуулаг	(950,000.00)	(950,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	295,075,000.00	295,075,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,780,522,708.55	7,876,790,461.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,780,522,708.55	7,876,790,461.81
51	Засгийн газрын хувь оролцоо	5,780,522,708.55	7,876,790,461.81
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,267,255,835.92	1,267,255,835.92
51101	Өмч: -Төрийн өмч	1,267,255,835.92	1,267,255,835.92
512	Хуримтлагдсан үр дүн	4,132,751,677.68	6,229,019,430.94
51210	Өмнөх үеийн үр дүн	4,132,751,677.68	4,132,751,677.68
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,096,267,753.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	380,515,194.95	380,515,194.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,780,522,708.55	7,876,790,461.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,812,760,338.00	7,288,032,231.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,870,312,852.00	4,185,395,727.20
120	Нийтлэг татварын бус орлого	3,580,012,706.00	3,591,823,509.92
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	220,898,411.00	3,591,823,509.92
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	220,898,411.00	3,591,823,509.92
120009	Бусад орлого	3,359,114,295.00	-
122	Тусламжийн орлого	290,300,146.00	593,572,217.28
122001	Хандив тусламж /дотоод/	290,300,146.00	593,572,217.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,942,447,486.00	3,102,636,504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,588,752,600.00	2,638,850,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,588,752,600.00	2,638,850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,694,886.00	463,786,504.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	280,000.00	77,500.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	240,590,786.00	295,137,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	112,824,100.00	168,571,780.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,776,898,443.48	5,191,764,477.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,776,898,443.48	5,191,764,477.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,615,202,949.08	5,113,261,054.94
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,052,307,440.00	2,253,087,924.00
210101	Цалин	1,450,275,473.00	1,313,262,600.00
210102	Нэмэгдэл цалин	559,461,967.00	897,354,324.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,570,000.00	42,471,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,839,663.00	94,462,371.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,176,182.00	26,100,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	15,516,091.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	13,212,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	3,347,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	40,663,481.00	36,286,980.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,926,956.00	142,864,272.00
210301	Гэрэл цахилгааны зардал	17,621,197.00	18,303,979.00
210302	Түлш, халаалтын зардал	55,128,459.00	57,156,695.00
210303	Цэвэр, бохир усны зардал	5,177,300.00	7,403,598.00
210304	Байрны түрээс	60,000,000.00	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	147,659,228.60	699,690,295.00
210401	Бичиг хэргийн материал	7,352,620.00	11,775,650.00
210402	Тээвэр, шатахууны зардал	121,860,178.60	94,112,338.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,573,600.00	2,669,116.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	16,872,830.00	591,133,191.00
2105	Норматив зардал	244,496,371.00	238,650,105.00
210501	Эм	4,505,200.00	1,969,050.00

210502	Хоол	151,179,400.00	131,218,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	88,811,771.00	105,462,815.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,308,270.09	15,528,779.00
210601	Багаж хэрэгсэл	30,756,570.09	3,498,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	199,400.00	-
210604	Урсгал засвар	31,352,300.00	12,029,979.00
2107	Томилолт, зочны зардал	28,720,300.00	166,081,099.00
210702	Дотоод томилолтын зардал	28,720,300.00	166,081,099.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	35,366,804.00	12,253,116.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,647,726.00	5,847,400.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	799,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,747,400.00	1,747,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,526,594.00	2,892,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	383,200.00	383,200.00
210807	Газрын төлбөр	2,262,584.00	1,383,052.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	851,577,916.39	1,490,643,093.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,129,086.00	674,565,722.28
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,937,400.00	8,378,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	547,511,430.39	807,698,771.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,695,494.40	78,503,423.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,786,700.00	66,416,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	136,786,700.00	66,416,980.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,088,794.40	9,535,643.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,088,794.40	9,535,643.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,820,000.00	2,550,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,820,000.00	2,550,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	3,035,861,894.52	2,096,267,753.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	16,866,666.67	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,866,666.67	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(16,866,666.67)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	3,018,995,227.85	2,096,267,753.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,232,607,632.00	3,696,208,721.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	290,300,146.00	593,572,217.28
122	Тусламжийн орлого	290,300,146.00	593,572,217.28
122001	Хандив тусламж /дотоод/	290,300,146.00	593,572,217.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,942,307,486.00	3,102,636,504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,588,752,600.00	2,638,850,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,588,752,600.00	2,638,850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,554,886.00	463,786,504.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	140,000.00	77,500.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	240,590,786.00	295,137,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	112,824,100.00	168,571,780.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,080,957,632.00	3,638,966,921.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,080,957,632.00	3,638,966,921.28
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,918,741,337.60	3,560,463,498.28
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,052,307,440.00	2,253,087,924.00
210101	Үндсэн цалин	1,450,275,473.00	1,313,262,600.00
210102	Нэмэгдэл	559,461,967.00	897,354,324.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,570,000.00	42,471,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,839,663.00	94,462,371.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,176,182.00	26,100,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	15,516,091.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	13,212,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	3,347,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	40,663,481.00	36,286,980.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	139,556,126.00	142,864,272.00
210301	Гэрэл цахилгааны зардал	17,544,867.00	18,303,979.00
210302	Түлш, халаалтын зардал	56,833,959.00	57,156,695.00
210303	Цэвэр, бохир усны зардал	5,177,300.00	7,403,598.00
210304	Байрны түрээс	60,000,000.00	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	127,795,558.60	102,311,634.00
210401	Бичиг хэрэг	5,393,800.00	9,876,660.00
210402	Тээвэр, шатахуун	110,261,658.60	69,166,218.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,573,600.00	2,702,256.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,566,500.00	20,566,500.00
2105	Норматив зардал	164,545,900.00	123,611,840.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,563,700.00	1,701,200.00
210502	Хоол, хүнс	148,994,000.00	121,910,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,988,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,733,400.00	15,846,400.00
210601	Багаж техник хэрэгсэл	10,650,900.00	3,498,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	891,000.00	-
210604	Урсгал засвар	27,191,500.00	12,347,600.00
2107	Томилолт, зочны зардал	28,720,300.00	166,081,099.00
210702	Дотоод албан томилолт	28,720,300.00	166,081,099.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,366,804.00	13,813,116.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	26,647,726.00	7,407,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	799,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,747,400.00	1,747,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,526,594.00	2,892,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	383,200.00	383,200.00
210807	Газрын төлбөр	2,262,584.00	1,383,052.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	276,876,146.00	648,384,842.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	274,119,046.00	638,628,742.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,757,100.00	9,756,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,216,294.40	78,503,423.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,307,500.00	66,416,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	137,307,500.00	66,416,980.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,088,794.40	9,535,643.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,088,794.40	9,535,643.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,820,000.00	2,550,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,820,000.00	2,550,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	151,650,000.00	57,241,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	151,650,000.00	57,241,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	151,650,000.00	57,241,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	151,650,000.00	57,241,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	151,650,000.00	57,241,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(151,650,000.00)	(57,241,800.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,267,255,835.92	380,515,194.95	4,132,751,677.68		5,780,522,708.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
Тайлант үеийн үр дүн			0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,267,255,835.92	380,515,194.95	4,132,751,677.68		5,780,522,708.55

202 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,267,255,835.92	380,515,194.95	4,132,751,677.68		5,780,522,708.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,267,255,835.92	380,515,194.95	4,132,751,677.68		5,780,522,708.55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн			2,096,267,753.26		2,096,267,753.26
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,267,255,835.92	380,515,194.95	6,229,019,430.94		7,876,790,461.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
21	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,638,850,000.00	2,629,314,357.00
210	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,638,850,000.00	2,629,314,357.00
2101	Бараа, үйлчилгээний зардал	2,631,852,400.00	2,622,316,757.00
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,253,088,600.00	2,253,087,924.00
210102	Үндсэн цалин	1,313,262,600.00	1,313,262,600.00
210103	Нэмэгдэл	897,355,000.00	897,354,324.00
2102	Унаа, болон бусад нөхөн олговор	42,471,000.00	42,471,000.00
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,542,900.00	94,462,371.00
210202	Тэтгэврийн даатгал	26,100,000.00	26,100,000.00
210203	Тэтгэмжийн даатгал	16,383,600.00	15,516,091.00
210204	ҮОМШӨ ний даатгал	13,212,300.00	13,212,300.00
210205	Ажилгүйдлийн даатгал	3,347,000.00	3,347,000.00
2103	Эрүүл мэндийн даатгал	37,500,000.00	36,286,980.00
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,760,100.00	82,864,272.00
210302	Гэрэл цахилгаан	22,259,300.00	18,303,979.00
210303	Түлш, халаалт	57,173,500.00	57,156,695.00
2104	Цэвэр, бохир ус	8,327,300.00	7,403,598.00
210401	Хангамж, бараа материалын зардал	35,732,300.00	35,731,274.00
210402	Бичиг хэрэг	2,253,800.00	2,253,800.00
210403	Тээвэр (шатахуун)	31,338,400.00	31,337,758.00
210406	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,573,600.00	1,573,216.00
2105	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	566,500.00	566,500.00
210501	Нормативт зардал	103,029,200.00	103,029,200.00
210502	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	701,200.00	701,200.00
2106	Хоол, хүнс	102,328,000.00	102,328,000.00
210601	Эд хогшил худалдан авах	28,496,400.00	28,496,400.00
210604	Багаж, техник, хэрэгсэл	21,498,800.00	21,498,800.00

2107	Урсгал засвар	6,997,600.00	6,997,600.00
210702	Томилолт, зочны зардал	1,076,100.00	1,076,100.00
2108	Дотоод албан томилолт	1,076,100.00	1,076,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,963,300.00	13,813,116.00
210803	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,407,400.00
210804	Даатгалын үйлчилгээ	1,747,400.00	1,747,400.00
210805	Тээврийн хэрэгслийн татвар	3,138,800.00	2,892,064.00
210807	Тээврийн хэрэгслийн оношилгоо	383,200.00	383,200.00
2201	Газрын төлбөр	3,693,900.00	1,383,052.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,163,500.00	9,756,100.00
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	7,407,400.00	-
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,756,100.00	9,756,100.00
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,997,600.00	6,997,600.00
213209	Бусад урсгал шилжүүлэг	6,997,600.00	6,997,600.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,997,600.00	6,997,600.00
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,638,850,000.00	2,638,850,000.00
131001	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,638,850,000.00	2,638,850,000.00
4	Улсын төсвөөс санхүүжих	2,638,850,000.00	2,638,850,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
61	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
62	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
620001	АЖИЛЛАГСДЫН ТОО	198.00	166.00
620002	Удирдах ажилтан	1.00	1.00
620003	Гүйцэтгэх ажилтан	182.00	150.00
2	Үйлчлэх ажилтан	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ /төгрөг/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,054,807,921.28
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	1,054,807,921.28
210	Бараа, үйлчилгээний зардал	-	995,388,541.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	60,000,000.00
210304	Байрны түрээс	-	60,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	79,880,360.00
210401	Бичиг хэрэг	-	7,622,860.00
210402	Тээвэр (шатахуун)	-	37,828,460.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	-	1,129,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	33,300,000.00
2105	Норматив зардал	-	20,582,640.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,000,000.00

210502	Хоол, хүнс	-	19,582,640.00
2106	Эд хогшил худалдан авах	-	5,350,000.00
210604	Урсгал засвар	-	5,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	165,004,999.00
210702	Дотоод албан томилолт	-	165,004,999.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	664,570,542.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	664,570,542.28
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	59,419,380.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	59,419,380.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	59,419,380.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,057,358,721.28
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	593,572,217.28
122001	Хандив тусламж /дотоод/	-	593,572,217.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	463,786,504.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	77,500.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	295,137,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	168,571,780.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	198.00	166.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	182.00	150.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Шижирболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 30/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын үйл ажиллагааны стратеги зорилго нь "Онцгой байдлын байгууллага нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдийн амь нас, эд хөрөнгө, байгалийн баялгийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгахад оршино" гэж тодорхойлжээ.

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газар 2019-2022 онд хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг цаг алдалгүй чанартай удирдан зохион байгуулах.
- Бэлтгэл бэлэн байдлыг хангах арга хэмжээг ирж бүрнээр хэрэгжүүлэх.
- Өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах.
- Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хүч оролцоог уялдуулан зохицуулах.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг даргын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Дотоод хяналтыг өргөн хүрээнд хийж байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бараа материал зарцуулалт, бүртгэл тооцоо санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хяналтыг хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 37,769.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,776,898.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 37,769.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 26,438.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 168,588.0 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	264,688.1	674,020.9	409,332.8
Биет хөрөнгө	5,220,759.6	6,907,694.5	1,686,934.9
Биет бус хөрөнгө	295,075.0	295,075.0	0.00
Нийт хөрөнгө	5,780,522.7	7,876,790.5	2,096,267.8
Хуримтлагдсан үр дүн	5,780,522.7	7,876,790.5	2,096,267.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,780,522.7	7,876,790.5	2,096,267.8

Бараа материалын дансны үлдэгдэл 409,332.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аймгийн онцгой комисс иргэд аж ахуйн нэгжийн хандив 979,881.1 мянган төгрөг, ОБЕГазраас 174,550.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 1,686,934.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ОБЕГазраас галын үндсэн албаны авто машин үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотойгоор нэмэгдсэн.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 00.0 мянган төгрөгөөр өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 2,096,267.8 мянган төгрөг болж өссөн нь тайлант оны хандивын бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлт зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 463,601.1 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 200,780.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 39,622.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,308.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 371,508.7 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 2,638,850.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн 2,638,850.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 2,638,850.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,638,850.0 мянга төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2,629,314.4 мянган төгрөгийг зарцуулж 9,535.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,629,314.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,080.5 мянга төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,895.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2,559.8 мянган төгрөг, хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргасан байна.

Аймгийн Засаг даргын захирамжуудаар цар тахалтай холбоотой дэмжлэг болон гамшгаас хамгаалах сургалтын зардал, ГТУА 44, 66 дугаар ангийн байрны түрээс, нутгийн дэм хөтөлбөрийн хүрээний дэмжлэг зэрэг нийт 295,137.2 мянган төгрөг, мөн ОБЕГазраас гамшгийн томилолт 1,2,3 дугаар улирал, ахмадын сангийн санхүүжилт, сэлгэлтийн зардалд нийт 168,571.8 төгрөг бусад байгууллагаас 77,5 мянган төгрөг цар тахалтай холбоотой хандив тусламж, дэмжлэгээр 593,572.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 1,054,807.9 мянган төгрөгийг зарцуулж, 2,550.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 218 ширхэг үндсэн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийг актлах, устгах, зарим ашиглах боломжтой үндсэн хөрөнгөнд үнэ тогтоох шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 173 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 1 акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цар тахалтай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн байна. Иймд дараагийн аудитаар тус бараа материалын зарцуулалтыг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 92,423.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 92,423.6 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд ажилтнуудын тоо зөрүүтэй,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд түлш, халаалтын зардал 3,360.0 мянга, цалингийн зардал 89,063.6 мянга, нийт 92,423.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Үлдэх өртөггүй 218 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 1:

УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 2:

Тайлант онд шилэн дансны сайтад 1, 4, 7 дугаар сарын Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.3.2 "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт"-т заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 2:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн онцгой байдлын газар	3	92,423.6	1	92,423.6	-	-	-	-	2	-